МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр Дугаар А/125 Мөрөн сум

Албан тушаалын тодорхойлолт
боловсруулах ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агентлаг, байгууллагын дарга нарын ажлын байрны шинжилгээ хийх шийдвэр гарсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнгөн-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	
М.Алтаншагай	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
Б.Оюунтуяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Батбилгүүн	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Янжиндолгор	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
Г.Базар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
М.Батчимэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Алтаншагай	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

671 0313497

2. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, байгууллагуудын ажлын байрны шинжилгээний дүнг танилцуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор албан тушаалын тодорхойлолтын шинэчлэн батлах төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР